



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 09 сарын 02 өдөр

Дугаар 8/436

Мөрөн сум

Барилга байгууламжийн ажлыг
хүлээж авах комисс томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.2, 35.1.6, 48 дугаар зүйлийн 48.6, Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хөвсгөл аймгийн Мөрөн суманд баригдсан “Эрч центр” ХХК-ны 72 айлын орон сууцны барилгын ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах чиг үүрэг бүхий комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:

Н.Шинэбаяр

(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын Барилга, хот
байгуулалтын хэлтсийн дарга)

Гишүүд:

Д.Сандагдорж	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн, Ерөнхий архитектор)
Б.Гал-Эрдэнэ	(Аймгийн Мэдээлэл холбоо сүлжээний хяналтын улсын байцаагч)
Д.Аюушжав	(Аймгийн Эрчим хүчний хяналтын улсын байцаагч)
Г.Ням-Эрдэнэ	(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасгийн Сан хөмрөгийн эрхлэгч)
Л.Бямбасүрэн	(Аймгийн Онцгой байдлын газрын Гамшгаас хамгаалах улсын хяналтын байцааг, дэд хурандаа)
Д.Аюуш	(Хөвсгөл Эрчим Хүч ХХК-ийн Ашиглалтын албаны дарга)
Ш.Баасанпүрэв	(Мөрөн сумын архитектор)
Б.Ганзориг	(Мөрөн хот тохижилт үйлчилгээний төв ХХК)
Ш.Нямханд	(Хөвсгөл дулааны станц ТӨХК-ийн ерөнхий инженер)
Д.Сүхээ	(Хөвсгөл Ус суваг ХХК-ийн ерөнхий инженер)
Ж.Лувсанням	(Мэдээлэл холбоо сүлжээ ТӨХК-ийн ерөнхий инженер)
Ц.Оюун-Эрдэнэ	(Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн дарга)
П.Хөвсгөлдалай	(Аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Өргөх байгууламжийн хяналтын улсын байцаагч)

Зураг төслийн байгууллагын төлөөлөл:

Г.Энх-Амгалан ("Гранд тех" ХХК-ийн захирал)

Б.Цолмонбаатар ("Гранд тех" ХХК-ийн инженер)

Гүйцэтгэгч байгууллагын төлөөлөл:

Э.Батсайхан ("Эрч центр" ХХК-ийн захирал)

Захиалагчийн төлөөлөл:

О.Баяраа Барилгын инженер

Комиссын нарийн бичгийн дарга:

Б.Энхжаргал (Газрын харилцаа, барилга, хот
байгуулалтын газрын мэргэжилтэн)


2.Мөрөн суманд баригдсан баригдсан "Эрч центр" ХХК-ны 72 айлын орон сууцны барилгын ажлыг хүлээж авах үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомжийн дагуу зохион байгуулж, комиссын ажлын тайлан, шийдвэрийг олон нийтэд мэдээлж ажиллахыг Комиссын дарга (Н.Шинэбаяр)-д даалгасугай.

3.Мөрөн суманд баригдсан баригдсан "Эрч центр" ХХК-ны 72 айлын орон сууцны барилгын ажлыг хүлээж авсантай холбоотой баримт бичгийг бүрдүүлэн аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн Архивын тасаг болон холбогдох байгууллагуудад хүлээлгэн өгөхийг Комиссын нарийн бичгийн дарга (Б.Энхжаргал) -д үүрэг болгосугай.

4.Комиссын бүрэлдэхүүн чанаргүй барилга байгууламж хүлээн авсан тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгүүлэхийг анхааруулсугай.

5.Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Э.Улам-Өсөх)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ